

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

Су.Батболдын хийсэн голлох ажил халаа сэлгээ гэв

Нийслэлийн засаг дарга Су.Батболд нь үүрэгт ажилдаа томилогдсоноос хойш 100 хоног өнгөрлөө. Энэхүү эхний зуун хоногийн хийсэн ажилд НИТХ-д суудалтай намын бүлгүүд болон Засаг дарга өөрөө үнэлэлт дүгнэлт өгч, иргэд шүүн тунгаадаг уламжлал тогтсон билээ. Өмнөх Нийслэлийн Засаг дарга томилогдоод 100 хоногт тээврийн хэрэгслийг улсын дугаараар ялган замын хөдөлгөөнд оролцуулж, төв замын нэгдүгээр эгнээг автобусанд чөлөөлөн өгч, замын түгжрэлийг бууруулах, иргэдийг нийтийн тээвэрээр шуурхай үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлэв. Хууль зөрчсөн газар олголтыг таслан зогсоох, зөрчилтэй барилга байгууламжийн үйл ажиллагааг зогсоож, цэгцлэх ажлыг эхлүүлсэн. ЕБС-ын хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор гэрэл ойлгогч цацруулагчтай цүнхний ууттай болгож, зүүж хэвшүүлэн, алслагдсан дүүргийн сурагчдыг сургуулийн автобусаар явуулах гэх зэрэг олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн билээ. Тэгвэл шинэ Засаг даргын 100 хоногийг АН-ын бүлэг дүгнэхдээ "100 хоног бүхэлдээ тайван налгар, шинэ санал санаачилга багатай, хойрго өнгөрлөө. Өмнөх Засаг дарга Э.Бат-Үүл эхний 100 хоногт 218 "А" захирамж гаргаж үүнээс ажил сайжруулах, удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр 65 захирамж гаргаж байсан бол Су.Батболд нийт 101 "А" захирамж гаргаснаас ажил сайжруулах, удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр 24 захирамж гаргасан нь үүний нэг жишээ. Засаг дарга Су.Батболдын хийсэн голлох ажлуудыг нэр хайг өөрчилсөн, халаа сэлгээ, хаалгаа хаасан, амлалтаасаа ухарсан, хойшоо тэмүүлсэн, налгар 100 хоног боллоо гэж дүгнэж болохоор байна" гэлээ.

УБТЗ-ЫН ШИНЭ ДАРГА ХАЛАА, СЭЛГЭЭНИЙ ХАЧИН ТОГТОЛЦООГ ХАЛЖ ЧАДЛАА



"УБТЗ"-ын даргыг сонгох тухай сураг гарахтай зэрэгцэн эхэлж, шинэ даргыг халаагаа өгөх хүртэл үргэлжилдэг байсан хэл ам энэ удаа "Мэргэжлийн засгийн газар" төмөр замын даргаар мэргэжлийн хүнийг тавих ёстой хэмээн урьдын адил нийгмийг оволзуулж эхэлсэн. Гэвч Д.Жигжиднямааг "УБТЗ"-ын даргаар томилсоноор энэ шуугиан нам гүм болов. Энэ нь сүүлийн жилүүдэд гарч байгаагүй онцгой үзэгдэл бөгөөд төр засаг олон нийтийн санаа бодлыг сонсож, нийгмийн шаардлагад нийсэн шийдвэр гаргаж чадвал ард олон төр засагтаа тэр болгон тэрсэлддэг байдаггүй юм гэдгийн тод жишээ юм.

Харин ч 2016 оны есдүгээр сарын 27-нд Москва

хотноо болсон Монгол-Оросын Хувь Нийлүүлсэн Нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ын Ерөнхий хорооны хурлын дараанаас эхлэн "Зөв шийдвэр, зөв хүн, зөв алхам" боллоо гэх мэдээлэл УБТЗ-ын эргэн тойрноос нийгэмд тарсан. Учир нь УБТЗ-ын даргаар төмөр замчиддаа төдийгүй хөрш орнуудынхаа зэргэлдээх төмөр замууддаа /Хөх хотын болон Дорнод сибир, Өвөр байгалын төмөр замуудад/

хүлээн зөвшөөрөгдсөн жинхэнэ удирдагчийг сонгож чадсан зөв шийдвэр боллоо гэж төмөр замчид хүлээн авсан хэрэг.

Шинэ дарга ажлаа дуулиан, шуугиан холио солиогүйгээр эхэлж байгаа нь бурууд дассан нийгмийг гайхшруулж байна гээд хэлчихэд нэг их дэгсдэхгүй биз. Зөвд нүдтэй төмөр замчидыг харин ч баярлуулж байна. Хүн амьдралдаа гэр бүл зохион үр удмаа үлдээж, ном бичиж, мод тарьсан бол

зөв амьдарчээ гэдэг. Тэгвэл 2016 оны аравдугаар сарын 03-ны өдөр тамгаа хүлээн авсан шинэ дарга аравдугаар сарын 05-ны өдөр эхэлсэн уламжлалт Монгол-Оросын найрамдлын сарыг тохиолдуулан Замын нэгдүгээр орлогч дарга А.В.Ушаковийг хүлээн авсан. Улмаар Монголын эрт эдүүгээгийн түүх соёлын талаархи орос номын цуглуулгыг УБТЗ-д ажиллаж буй орос мэргэжилтэнүүдийн төлөөлөлд гардуулан өгсөнөөр нэгэн шинэ номын сангийн тулгын чулуу тавигдав. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан бүх нийтээр мод тарих ажлын хүрээнд Үндэсний соёл амралтын хүрээнд төмөр замчдын төгөл бий болгох санаачилга гарган эхний ээлжинд 50 мод суулгахаар болсон зэрэг нь зөв хүний үйлдэл гэдэгтэй хэн ч маргахгүй биз ээ.

Үүний дараа шинэ замын дарга УБТЗ-ыг өвлийн тээвэрт бэлэн байлгах замын даргын үзлэгийг замын хойд хэсгээс эхлүүлэн төмөр замчид өөрөөс нь юу хүсэн хүлээн байгааг өөрийн чихээр сонсохоор ажилдаа идэвхийлэн орсныг зөв алхам гэхээс өөр юу гэх билээ. Тэр болгон замын даргатайгаа нүүр тулан уулзаад байж чаддаггүй хөдөө орон нутгийн шугам замын төмөр замчид өөрсдийг нь зориод ирсэн шинэ даргатайгаа уулзан санал, хүсэлтээ дуулгаж чадсандаа баяртай байгаа сурагтай. Тиймээс шинэ замын даргын ажлын гараа зөв байна хэмээн төмөр замчид ам сайтай байна.

МЭДЭЭЛЭЛ

Ерөнхий сайд УИХ-д мэдээлэл хийнэ

УИХ-ын дарга М.Энхболдод ЗГХЭГ-ын дарга З.Мөнхбат албан бичиг хүргүүлжээ. Тэрбээр Ерөнхий сайд аравдугаар сарын 21-нд аравдугаар сарын 21-нд чуулганы нэгдсэн хуралдаан дээр мэдээлэл хийхээр болсон тухай мэдэгдсэн байна. Уг албан бичигт "Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат УИХ-ын 2016 оны аравдугаар сарын 21-ний өдрийн

Чуулганы нэгдсэн хуралдаанд Төрийн өмчийн болон өмчийн бус сургууль, цэцэрлэгийн өнөөгийн байдал, цэцэрлэгийн болон сургуулийн насны хүүхдүүд бүрэн хамрагдах боломжийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл хийх болсныг уламжилж байна" гэжээ.



МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч:	С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч	Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга:	Э.ЭНХЦЭЦЭГ 88873012
Ахлах редактор:	Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба	Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:	Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба:	Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба:	Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба:	Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба:	М.ДАВААДУЛАМ 99042510
	Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхэлсэн	Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.
2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.


МАН-ын ямбатнууд Япон руу визгүй зорчих нь

Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын өнгөрсөн өнөрүүдэд Япон Улсад дөрөв хоногийн айлчлал хийсэн. Энэхүү айлчлалын хүрээнд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат тус улсын Ерөнхий сайд Ш.Абэтэй уулзаж албан ёсны хэлэлцээ хийхийн зэрэгцээ Японоос хөрөнгө оруулалт татаж, эдийн засгаа сэргээхийг хүсч буйгаа илэрхийлээд ирсэн. Түүний өөр нэг амжуулсан ажил нь дипломат паспорттой хүмүүсийг 30 хоног визгүй зорчих эрхтэй болгосон явдал. Гэхдээ үүнийг МАН-ын ямбатнуудад зориулсан үйл ажиллагаа гээд хэлчихэд хилсдэхгүй. Учир нь дипломат паспорт гэдэг бол энгийн ард түмэнд ямар ч пядий байхгүй зүйл. Учир нь дипломат паспортыг зөвхөн ямбатнууд л эзэмшдэг гэдгийг хүн бүхэн мэдэж байгаа шүү дээ.

Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

АЙЛЧЛАЛ

М.Энхболд: Японы туслалцааг аваагүй салбар Монгол Улсад байхгүй



УИХ-ын, МАН-ын дарга М.Энхболд БНХАУ-ын Чунчин хотод "Хятад ба Дэлхийн яриа хэлэлцээ" хуралд оролцлоо. Энэхүү хурал нь гурав дах жилдээ зохион байгуулагдаж байгаа бөгөөд Англи, Франц, Герман, Япон, ОХУ зэрэг 50 гаруй орны төлөөлөл оролцож байна. Энэ жил "Дэлхийн эдийн засгийн төгөлдөршил: Улс төрийн намуудын үзэл баримтлал, үйл ажиллагаа" сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа аж. Энэхүү хурлын нээлтийн ажиллагааны дараа УИХ-ын дарга М.Энхболд Япон улсын парламент дахь Япон-Монголын парламентын бүлгийн дарга Хаяашиг хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд Япон улсын парламентын дахь Япон-Монголын парламентын бүлгийн дарга Хаяаши "Монгол улсад болсон УИХ-ын сонгуульд МАН ялалт байгууланд хүргэе. Япон Монгол хоёр орны харилцаа нийгэм эдийн засгийн бүхий л салбарт сайн байгаа. Яг энэ цаг мөчид Монгол Улсын Ерөнхий сайд Япон улсад айлчилж байгаа бөгөөд Япон Монгол хоёр орны ерөнхий сайд нар уулзаж байна. Цаашид Япон Монгол хоёр орон, хоёр орны парламент хоорондын харилцаа илүү сайн хөгжино гэдэгт итгэлтэй байна" гэдгийг онцлон хэлсэн. Харин УИХ-ын дарга М.Энхболд хэлсэн үгэндээ "Хоёр орны хамтын ажиллагаа нийгмийн бүхий л салбарт сайн хөгжиж ирсэн. Монгол Улсын эдийн засгийн хямралтай цаг мөч болгонд Япон улс, Японы ард түмэн байнга тусалж, дэмжиж ирсэнд баяртай байдаг. Япон улсын дэмжлэг, туслалцааг аваагүй салбар гэж

Монгол Улсад байхгүй. Тун удахгүй Монгол Улсад Олон улсын шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орно. 10 жилийн өмнө би Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа Япон улсын Ерөнхий сайд Коземутай уулзаж энэ их бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх гарын үсгийг зурж байсан. Үүнээс гадна Монгол Улсад эдийн засгийн амаргүй байдал үүсээд байна. Гадаад өрийн хэмжээ их, их хэмжээний өрийн төлөлт тун удахгүй эхэлнэ, эдийн засгийн өсөлт дөнгөж 0.6 хувьтай гээд хүндрэлтэй нөхцөлд байна. Энэхүү эдийн засгийн хүндрэлтэй байдалд Япон улсын засгийн газар анхаарал тавих гэж найдаж байгаа" гэдгийг онцлолоо. Улмаар Япон-Монголын парламентын бүлгийн дарга ноён Хаяаши "Япон улс Монгол Улсын эдийн засгийн байдлыг сайн ойлгож байгаа. Хоёр орны харилцаа олон жил олон шатаанд хөгжиж ирсэн. Иймээс Япон улсад очсон хойноо Монгол Улсад тулгамдаж байгаа асуудлыг уламжилж хэлнэ" гэдгээ тодотголоо. Уулзалтын төгсгөлд ноён Хаяаши Монгол, Японы залууст зориулсан төсөл боловсруулж байгаа. Удахгүй үүнийг танилцуулна. Өмнө нь Монгол Улсын биеийн тамирын чиглэл дээр тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд өнөөдөр Монголоос зургаан хүн Япон улсад суралцаж байгаа.Цаашид ер нь хоёр улсын ХАА-н салбарын хамтын ажиллагааны чиглэлээр Хокайда мужид залуусыг ажлуулах, мэргэжүүлэх зорилготой байгаагаа дуулгасан юм.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр
Өндөр боловсрол
ЭЗЭМШИХ ХЭРЭГ
байна уу

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Дараа нь зууны манлай дуучин МУГЖ Б.Сарантуяа СТӨ-ний дэд дарга болж, албан тушаалын бялуу хүртсэн бол “Номин талст”-ынхан түүний халааг залгамжлан авч, хамтлагийн ахлагч Д.Батсүх нь Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргаар томилогдсон. Харин дуучин А.Хаянхярваа нь нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын дэд даргын албан тушаалд очих нь тэр. Түүнчлэн, нэгэн үе зохиолын дууны ханхүү гэгдэж, МУГЖ цол хүртэж явсан Ч.Бат-Эрдэнэ Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын дарга болсон гэх мэдээлэл ч байна.

Монголд тэдгээр албан тушаалд томилогдох чадвартай номын дууг нь сонсч, ногоотой шөлийг нь уусан мэргэжилтнүүд бий. Бид хэдийгээр эдийн засгийн хямралд өртөж, уух ус, идэх хоолоо хэмжих дээрээ тулсан ч, боловсон хүчний хомсдолд арай ч орчихоогүй байна. Гэтэл олон жилийн турш өөрийн хүч чармайлтынхаа хүчээр сайн, чанартай их дээд сургууль төгсч, хэдэн орны хэлээр төвөггүйхэн ойлголцчихдог боловсон хүчин намд элсээгүй, эсвэл хэн нэгэн эрх мэдэлтний цүнхийг барьж, сурталчилгаанд нь ажиллаагүйнхээ төлөө урлагийнхнаас доогуур үнэлэгдэх хачирхалтай тогтолоо нэгэнт бий болчихжээ. Намд элссэн хэн дуртай нь төрийн албаны чухал салбарыг толгойлдог болсон юм бол халаасаа тэмтчин байж өндөр боловсрол эзэмших хэрэг байна уу.

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар гэдэг бол төрийн чухал агентлаг. Гэтэл 2004 онд намд элсч, 2008 оноос улстөрд орохыг санаархаж, 2012 оны сум, дүүргийн ИТХ-д нэр дэвшээд өвдөг шороодсон эрхмээр дутаагүй л байлтай. Дуучин А.Хаянаагийн хувьд урлагийнхан дундаа өндөр боловсролтой тооцогддог гэдэг. Учир нь тэрбээр Тагнуулын дээд сургуулийг төгссөн юм байх. Харин нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын албан тушаалд томилогдсон Д.Батсүх СУИС-ийг дуулаачийн мэргэжлээр төгссөнийхөө дараа МУИС-ийг Эрх зүйч мэргэжлээр дүүргэсэн гэнэ билээ. “Нам дагавал ам тосдоно” гэдэгчлэн, ийм боловсролтой эрхэм эзэмшсэн мэргэжлээсээ тэс өөр салбар руу хальж, нийслэлийн Аялал жуулчлалын газрыг толгойлж эхлэв. Үндсэндээ “Номин талст”-ынхнаас ганц Т.Дэлгэрмөрөн л даргын алба хашиж үзэлгүй үлдлээ. Өмнө нь тус хамтлагийн Хаазаа буюу Т.Хангэрэл Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын Харьяатын хэлтсийн даргын үүргийг гүйцэтгэж байгаад албан тушаалаасаа буусан юм билээ. Урлагийнхан гэдэг ард түмнийг соён гэгээрүүлэх үүрэг, хариуцлага хүлэсэн хүмүүс. Гэвч энэ удаа арай л өөрөөр үлгэрлээд байна уу даа. Үндсэндээ залууст цаг хугацаа, мөнгө хөрөнгөө үрэн байж чанартай боловсрол эзэмшсэний оронд эртхэн долоон нот цээжлэн хэдэн дуу дуулах, эсвэл нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ажиллаж, намд элссэн нь хавь илүү албан тушаалд хүргэдэг гэдгийг үлгэрлэж буй хэрэг бус уу.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



“
ОЁО оооёёё ÷áíàððàè
ààðààààà, ÷÷íýýñ äòðàððàéäýýð
Çàñàèèí ààçàðð ì àø ñàéí
öýíàèò òààüæ àæèèèààà
ààéò ñòíé. áí°ä°ð
ì àíàé ОЁО үíý ÷÷äýý
òí àððààà, àéàáí òòøààé,
ì °íá° òòàààððèèàà, Çàñàèèí
ààçðóí àæèèä òòààèèààà
ààéäòòèèàà áí è÷èòí í à ààéíà.
”

УИХ-ын гишүүн асан

М.Байтымзи

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

ҮЗЭЛ БОДОЛ

МАН “ТОЛГОЙТОЙ” ТӨРД АН “ХӨЛ” ЗАЛГАЯ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Ийм дүүрчихсэн “толгойтой” төрд ядаж л бага ч болов хяналт, тэнцвэр хэрэгтэй байна. Тиймээс орон нутгийн сонгуульд АН ялах хэрэгтэй байгаа юм. Тэгж байж энэ төрд бага ч болов хяналт тогтоно. Ядаж Улаанбаатар хотын хэдэн дүүрэг, хороо, Монгол Улсын 360 гаруй сумын ихэнхэд нь АН засаг бариад эхэлбэл хүч тэнцвэржинэ. Тэд төрд байгаа эрх мэдэлтнүүдээс, Засгийн газраас зөв бодлого нэхнэ, шаардана. Ядаж л Сум хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгийг нэхнэ. Сум, орон нутагт хамгийн хэрэгтэй бодлогуудыг үргэлжлүүлэхийг шаардана. Угаасаа хяналттай зүйл л хамгийн зөв байдаг. Ямар ч хяналтгүй, дураараа авирлаад эхэлбэл эцэс сүүлдээ эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан хэдэн хүнээс өөр юу ч үлдэхгүй, энэ улс оронд. Өнөөдөр Монгол Улсын эдийн засаг ямар байгаа билээ. Элгээрээ мөлхсөн. Эдийн засгийн өсөлт гэж алга. Оюултой хөдөлж, ашигт малтмалын үнэ дэлхийн зах зээлд дээр өсч байх үед олсон хэдэн төгрөгөө манайхан ганц жилийн дотор тансаглаад л дуусгасан. Мөн төрийн эрх мэдэлтнүүд нь “өвөртөө хийгээд”, гадаадын татваргүй бүсэд аваачаад хав дарчихсан гэж ярих хүмүүс ч бий. Олны үг ортой л гэдэг. Тэгээд өнөөдөр олох орлого нь буураад эхлэхээр ард түмнийхээ халаасыг эвтэйхэн сэгсэрч, төсвийн алдагдлаа бага ч болов бууруулах гэж үзэж байна, энэ төрийнхөн. Мөн өмнөд хөршөөс баахан мөнгө зээлж, Хятадаас эдийн засгийн бүрэн хараат болох замыг л сонгож эхлэв бололтой. Ийм л эмх замбараагүй, дураараа авирласан үйлдлийг эрх баригчид хийж байна. Ядаж байхад дураараа авирлахдаа зөв зам сонгохгүй юм. Энэ төрд ядаж л олон улсын жишээ жишгийг хараад ажиллачих чадвартай хүн алга байна. Ганц гарцаа Хятад гээд л итгэчихсэн бололтой. Ийм л “толгойтой” төрд одоо яг ижилхэн “хөл” залгавал буруу зам руугаа бүр л хурдан алхана шүү дээ. Тиймээс орон нутагт арай өөр сонголт хийе. Ядаж л зөв бодолтой, чадвартай, мэдлэгтэй хүмүүсийг дүүрэг,

...“Сонгосон шиг сонгочихоод, дөрвөн жилийн дараа дүнгээ тавь” гэнэ үү. Юун дөрвөн жил, ард түмэн аль хэдийнэ Засгийн газар байгуулагдахад, сайдууд томилоход, бүх тэтгэмжийг хүрсэн төвшнөөс буулгахад, ард түмний ялгаварлан гадуурхахад л дүнгээ тавьчихсан...

сумын Засаг даргаар сонгогдох замыг нь засч өгөх хэрэгтэй шүү дээ. МАН-ынхан бол орон нутгийн сонгуулиар хийж байгаа ганц сурталчилгаа сонгосон шиг сонгоё гэх үг. Бид хаашаа ч явж магадгүй, тэр нь буруу байсан ч манай намыг нэг мөсөн сонгочих гэж байгаа бололтой юм. 2000 онд сонгосон л биз дээ. Бүр сонгосон шиг сонгосон. Тэгээд яасан билээ. Нэг их олигтой юм хийгээд, засч янзлаад, өөд нь татчихсан юм байхгүй. Ядаж л нийслэлийнхээ замыг ч засчихаагүй шүү дээ. Зайлшгүй хийх ёстой ажлуудаа ч хийж байгаагүй. Тэгээд одоо дахиад сонгосон шиг сонго гээд байгаа нь юу ч гэсэн үг юм. Сая баахан хэрэггүй хэрэггүй нөхдүүд УИХ-д гараад суучихлаа. Жаахан эрдэмтэй, мэдлэгтэй гэсэн болгоноо яам, тамгийн газар, нийслэлд аваачаад ямар нэг албан тушаал өгчихлөө. Одоо тэгээд МАН-д анхан шатны төрийн байгууллагуудад ажиллачих хүн боловсон хүчин байна уу. Сангийн сайд хийчих хүн олдохгүй нэг Увсын нэг нөхрийг томилж байгаа намд дүүргийн Засаг дарга хийчих чадвартай хүн үлдсэн үү. Тэгээд

бас “Сонгосон шиг сонгочихоод, дөрвөн жилийн дараа дүнгээ тавь” гэнэ үү. Юун дөрвөн жил, ард түмэн аль хэдийнэ Засгийн газар байгуулагдахад, сайдууд томилоход, бүх тэтгэмжийг хүрсэн төвшнөөс буулгахад, ард

түмний ялгаварлан гадуурхахад л дүнгээ тавьчихсан. Дахинд хэдэн жил хүлээх хэрэг байхгүй. Тийм болохоор одоо сонголтгоо өөрөөр хийх байх. Өөрөөр хийгээсэй ч гэж хүсч байна. Төрд хяналт хэрэгтэй.

Амаа авч давхидаг, хөөрдөг, хадурдаг морины “ам”-ыг татаж байж зөв замаараа явж, зорьсон газраа хүрэх бус уу. Одоо манай төрд “ам”-ыг нь татчих сөрөг хүчин л хэрэгтэй байна даа.

ТАЛ НУТГИЙН
ЦАХИМ
МЭДЭЭЛЭЛ

**Манай сайт
аппликейшнтэй
боллоо**

MMINFO АПП

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATAX
PLAY STORE

TATAX
APP STORE

ЭДИЙН ЗАСАГ

АЛБАНЫ ХУНИЙ ҮГ



Х.ХЭРЛЭН:

төвийн үйл ажиллагаа эхлэх үед хоёр тал хамтын ажиллагаагаа цаашид өргөжүүлэн ажиллах юм.

-Тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулахад мэргэшсэн хамт олон чухал үүрэг гүйцэтгэх нь мэдээжийн хэрэг. Тэгвэл хүний нөөцийн асуудал дээр ямар бодлого баримталж, хэрхэн хэрэгжүүлж байна вэ?

-Тийм ээ. Чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх гол хүчин зүйл бол чадварлаг боловсон хүчин юм. Компанийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай уялдуулж, хүний нөөцөө бүрдүүлэх, цаашид хийх ажлын хүрээнд хамааран

МСҮГ-д төмөр замын мэргэжлээр нийт 500 орчим боловсон хүчин бэлтгэгдээд байна.

-Байгууллага бүр өөрсдийн бахархах, үнэт зүйлтэй байдаг. Танай байгууллагад бусдаас онцлог, ямар давуу тал байдаг вэ?

-Манай байгууллагын дийлэнх нь залуучууд. Тус бүр өөрийн зорилготой, төмөр замын бүтээн байгуулалтад гар бие оролцож буй чадварлаг, төрөл бүрийн мэргэжилтэй боловсон хүчний бүрэлдэхүүнтэй. Тухайлбал, ОХУ, БНХАУ, Энэтхэг, Турк, Япон, Солонгос улсуудад мэргэжил

ОН ДУУСТАЛ НЭГ САЯ ТОНН АЧАА ТЭЭВЭРЛЭНЭ

Үргэлжлэл. Түүрч нь I нүүрт

Бидэнхүү тээвэрлэлтээ өөрийн эзэмшлийн вагон, зүтгүүрээр тээвэрлэж байгаа нь хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтыг сайжруулах, орчин үеийн техник, технологийг эзэмшиж сурах, мөн Монгол Улсын ачаа тээх чадварыг нэмэгдүүлэх үйлсэд чухал хувь нэмэр оруулж байгаа үйл явц юм. Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт туссан Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын ажлыг эхлүүлэхийн тулд "Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт тухайн чиглэлийн төмөр замыг нэмэлтээр тусгуулахаар холбогдох судалгаа, танилцуулга бэлтгэж Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох газарт хүргүүлсэн. Мөн Засгийн газрын хөтөлбөрт багтсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр замын эдийн засгийн тооцоо судалгаа, Шивээхүрэн боомтын асуудлаар танилцуулга, холбогдох судалгааг бэлтгэн салбарын яаманд тус тус хүргүүлээд байна. Хөт-Бичигийн төмөр замын ТЭЗҮ боловсруулах ажлыг БНХАУ-ын Төмөр замын гуравдугаар товчоотой хамтран эхлүүлсэн, ирэх арваннэгдүгээр сарын 15 гэхэд эцсийн ажиллагаа хүлээн авахаар талууд шаргуу ажиллаж байгаа, залуулаад төсөл хэрэгжүүлэх ажлыг ЗТХЯ-ны чиглэл, удирдамжийн дагуу хэрэгжүүлнэ. Түүнчлэн Монгол Улсад хэрэгжих эдийн засгийн ач холбогдолтой, ачаа тээвэр, ложистикийн үйл ажиллагааг дэмжсэн төслүүдийн талаар судалгаа хийж, хэрэгжүүлэхээр төлөвлөд байгаа. Жишээ дурьдвал, "Ачааны вагон үйлдвэрлэх, угсрах" төсөл байна. Манай улсад өнөөгийн байдлаар 6200 орчим ачааны вагон ашиглагдаж байна. Үүнээс 44 хувь нь буюу ойролцоогоор 2700 орчим ачааны вагоны ашиглалтын хугацаа дууссан. Өөрөөр хэлбэл, 25-аас дээш жил ашиглагдаж байгаа судалгаа байна. Ийм вагоныг тээвэрлэлтэд ашиглах нь хөдөлгөөний аюулгүй байдалд маш их эрсдлийг дагуулдаг, ачааны вагонуудыг ойрын хугацаанд зайлшгүй парк шинэчлэлтээр солих шаардлагатай. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаас гадна дээр дурьдсан Оюутолгойн салаа төмөр зам, Шивээхүрэн-Сэхэгийн боомтын төмөр зам, Хөт-Бичигийн болон Эрдэнэт-Овоотын төмөр замууд ээлж дараагаар баригдаж ашиглалтад орсны дараа ачааны вагоны паркгүйгүлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор урган гарна. Үүнээс гадна "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт тусгагдсан бусад чиглэлийн төмөр замын төслүүд ч мөн эхэлнэ. Тиймээс эдгээр төмөр замын төслүүд хэрэгжиж дуусаад төмөр зам ашиглалтад орохтой зэрэгцээд парк шинэчлэлтэд ойролцоогоор 10 мянга орчим хагас вагоны эрэлт хэрэгцээ, шаардлага гарах юм. Эдгээр вагоныг импортоор

авна гэвэл та бидний мөнгө гадагшаа зүгээр л урсах болно. Тиймээс энэхүү төслийн хүрээнд өргөн, нарийн царигийн хагас вагон үйлдвэрлэх, их засвар хийх, зориулалт бүхий "Ачааны вагоны үйлдвэр"-ийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Одоогоор ажлын хэсгийнхэн БНХАУ, Орос, Украин, ХБНГУ, Казахстан, Узбекистан зэрэг орны ижил төстэй үйлдвэрүүдээс туршлага судалж, тооцоо судалгаа хийж боловсруулаад байна. Урьдчилсан ТЭЗҮ-ийг салбарын хэмжээнд хэлэлцүүлж хийж, ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хуралд оруулж, хуралдаанаас эдийн засгийн үр ашгтай төсөл хэмээн дэмжсэн дүгнэлт гарсан.

-Тээвэр, ложистикийн төв байгуулах ажил ямар шатандаа явж байгаа вэ?

-Монголын төмөр зам" ТӨХК-ийн зүгээс энэ төслийн ажлыг эхлүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна. Төслийн хүрээнд саяхан манай мэргэжилтнүүд БНХАУ-ын Тяньжин хотод ажиллаад ирсэн. Тяньжин хотын Бинхай шинэ бүсэд зохион байгуулагдсан "Зүүн хойд азийн Энхтайван, хөгжлийн Бинхай-2016" чуулганд оролцож "Монгол-ОХУ-БНХАУ гурван улсын хамтын ажиллагаа эдийн засгийн коридор" сэдвээр илтгэл тавьсан. Уг хурлын үеэр бид "Тяньжин ложистикийн төв" төсөл болон "Тавантолгой-Гашуун сухайт" төмөр замын төсөл, "Хөт бичигт чиглэлийн" төмөр замын төслийн талаар Хятадын талын томоохон компаниудын удирдлагуудад танилцуулж, эдгээр төслүүд дээр хамтран ажиллах хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа талаар танилцуулсан, хөрөнгө оруулалт шийдэгдсэнээр төслийг хэрэгжүүлэх хамтарсан компани байгуулаад барилгын ажил явагдаж дуусаад, боомтын үйл ажиллагаа эхлэх юм. Үйл ажиллагаа эхлэхэд шаардлагатай үйлдвэрлэлийн судалгаануудыг хийж байна. Жишээ нь, Махны экспортыг нэмэгдүүлэх, мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэн Хятад болон гуравдагч орны зах зээлд нийлүүлэх, малын боловсруулсан арьс, ширийг эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрлэл, чацарганыг боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортоор орж ирдэг өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнүүдийг жижиглэнгээр савлах, боловсруулах зэрэг эдийн засгийн ач холбогдолтой төслүүд дээр ажиллаж байна. Дунзаны чөлөөт худалдааны боомт бүсэд дээрх үйлдвэрлэлийг явуулахад чөлөөт бүсийн хөнгөлөлтүүдийг эдлэхээс гадна Монголоос түүхий эдийг оруулахад гаалийн татвар, боловсруулалтад НӨАТ төлөхгүйгээс гадагш үйлдвэрлэлийн далайн боомтод хөгжүүлснээр экспортоо нэмэгдүүлэх, тээвэр, ложистикийн зардлыг бууруулах давуу талтай.

-Шинэ төмөр зам" төслийн хүрээнд төмөр замын бүтээн байгуулалтыг "Монголын төмөр зам" компани хэрэгжүүлж байна. Энэ ажил ямар

шатандаа явж байгаа бол?

-УИХ-аас 2010 онд батлагдсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д тусгагдсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын доод бүтцийн ажил 85 хувьтай байна. Бид "Шинэ төмөр зам" төслийг хэрэгжүүлэх гадаадын хөрөнгө оруулагчдыг судалж, яриа хэлэлцээр хийж байна. Тухайлбал, "Тавантолгой-Сайншанд-Хөт-Чойбалсан чиглэлийн төслийн талаар Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбагын Япон Улсад хийх албан ёсны айлчлалын үеэр хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж, танилцуулга бэлтгэсэн, тиймээс зүүн чиглэлийн төмөр замын төслийн асуудалд дөвшил гарах байх гэсэн хүлээлт байгаа. Айлчлалын бүрэлдэхүүнд мөн Зам, тээврийн хөгжлийн сайд багтсан.

-Төмөр зам барьснаар улс оронд ямар үр өгөөжтэй байх асуудлыг нийгэм олон янзаар хүлээн авч байна. Монголынхоо баялгийг төмөр замаар гаргаад дууслаа гэх мэтээр сөргөөр харах нь илүү байж магадгүй юм?

-Монгол Улс нь стратегийн чухал ач холбогдолтой орд газруудаа яаж эдийн засгийн эргэлтэд оруулж, хэрхэн үнэт хургах вэ гэдгээ маш сайн төлөвлөж, өнөөгийн нөхцөл байдалаа оновчтой харж байж хэрэгжүүлэх шаардлагатай гэж санагддаг. Төмөр зам, цахилгаан станц, аж үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулах ёстойг хэн хүнгүй ярьдаг, харин ямар шат дараалал, менежментээр бүтээн байгуулах вэ гэдгээ эв тодорхойлох хэрэгтэй. Миний бодлоор санхүүгийн боломждоо тааруулж, төмөр замаа барьснааад ашигт малтмалаа тээвэрлэж орлогоо бүрдүүлснээр дараагийн томоохон төслүүдэд явуулах ёстой гэж боддог. Тэгээгүй учраас эдгээр төслүүд бүгд зэрэг эхлээд хөрөнгийн дутагдлаас болж зэрэг зогсолт хийгдээд байгаа нь нийгэмд нэгэнт ил болсон байдал юм.

-“Монголын төмөр зам” ТӨХК нь өнөөдрийн байдлаар хэдий хэмжээний хөдлөх бүрэлдэхүүний парктайгаар үйл ажиллагаа явуулж байна вэ?

-Манай компани нийт 245 ачааны вагон, ОХУ, БНХАУ болон АНУ-д үйлдвэрлэсэн өндөр хүчин чадал бүхий сөн зүтгүүр, хоёр чингэлэг өргөгч машинтайгаар үйл ажиллагаа явуулдаг. Мөн Дорноговь аймгийн Замын-Үүд суманд байрлах "Ачаа шилжүүлэн ачих байгууламж"-ийг 80 га газрын хамтаар эзэмшдэг. Төмөр замын суурь бүтцийн хувьд Замын-Үүд дэх шилжүүлэн ачих байгууламжид хамаарах 8.4 км төмөр зам болон дээр дурьдсан Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө сумдын хооронд байрлах 33.4 км төмөр зам бий.

-“УБТЗ” ХНН-тэй хэрхэн хамтран ажиллаж байна вэ. Хоёр талын байгууллагын хооронд хийж хэрэгжүүлсэн, цаашид хамтран хэрэгжүүлэх ажлуудын талаар ярьвал?

-Манай компани өөрийн эзэмшлийн хөдлөх бүрэлдэхүүн, машин механизм, тоног төхөөрөмжийг "УБТЗ" ХНН-

тэй хамтран тээвэрт явуулахаас гадна үндэсний аж ахуйн нэгж, уул уурхайн компаниудад өөрийн хөдлөх бүрэлдэхүүнээр тээврийн үйлчилгээ үзүүлдэг. Үүгээрээ Монгол Улсын төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, ачааллыг хөнгөвчлөх, үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг өсгөх зэрэг бүхий л талаар хамтран ажилласаар ирсэн. Өнөөдрийн байдлаар бид төмөр замын дамжин өнгөрүүлэх чадварыг сайжруулах зорилгоор Замын-Үүд дэх Япон Улсын буцалтгүй тусламжаар барьж байгуулсан шилжүүлэн ачих байгууламж, түүнд дагалдах тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах үүднээс "УБТЗ" ХНН-тэй хамтран ажиллаж байна. Түүнчлэн Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдаж буй Замын-Үүдийн Ложистикийн

мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх гэх зэрэг ажлуудыг хийж байна. Дээр дурьдсан төмрийн хүдрийн тээврийн үйл ажиллагааг явуулахад инженер, техникийн нийлсэн 60 орчим ажилтанг сонгон шалгаруулан орон нутагт ажиллуулж байна. Мөн ирээдүйд биелэлээ олох төсөл хөтөлбөрүүдийг угтаж, БНХАУ-ын Зам, тээврийн дээд сургуульд компанийнхаа нэр дээр 13 оюутныг таван төрлийн мэргэжлээр, Монгол Улсын Тээврийн дээд сургуульд гурван оюутныг компанийн тэтгэлэгт хөтөлбөрт хамруулан, суралцуулж байна. Түүнчлэн богино хугацаанд мэргэшүүлэх үүднээс Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран ажилладаг. Тухайлбал, төмөр замын МСҮГ-д компанийн нэр дээр найман оюутан суралцаж байгаа бол Налайх, Сайншандын

эзэмшсэн боловсон хүчнүүд байна. Ямар ч төсөл дээр ажиллах мэдлэг боловсрол мэдлэг чадвар тэдэнд бий. Тиймээс Монгол Улсын хөгжил дэвшил, дэд бүтцэд хөрөнгө оруулж буйгаараа бид бүхэн бахархдаг.

-Цаашид ямар ажлуудыг хийж, хэрэгжүүлэхээр төлөвлөд байна вэ?

-Эхлүүлсэн, гүйцэтгэж байгаа ажлуудынхаа хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахаас гадна төмөр замд шаардлагатай 150 орчим төрлийн дүрэм, журам боловсруулах, олон улсын сайн туршлагад тулгуурласан стандартуудыг нутагшуулах, төмөр замын тээврийн эрх зүйн холбогдолтой хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах, засан сайжруулах зэрэг ажилд салбарын яамтайгаа хамтран ажиллахаар төлөвлөд байна.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ашигт малтмалын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.6, 34.7 дахь хэсэгт заасны дагуу тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг алдангийн хамт төлөөгүй, төн хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн дараах аж ахуйн нэгжийн ашигт малтмалын

№	Тусгай зөвшөөрлийн төрөл, дугаар	Анх олгосон огноо	Аймаг, хот	Сум, дүүрэг	Талбайн нэр	Аж ахуйн нэгжийн нэр
1	МУ-014981	2004.06.11	Дорноговь	Айраг	Яшил	Орчлон-Айрон ХХК
2	МУ-016846	2011.06.15	Өвөрхангай	Хужирт	Олонтүрүү	Монскорп ХХК
3	МУ-017564	2014.07.02	Баян-Өлгий	Ногооннуур	Баруун талын уул	ЖӨН ЮАН ХХК
4	ХУ-018664	2015.07.02	Увс	Өмнөговь, Тариалан	Тээл	Цагаантамич ХХК
5	ХУ-017561	2009.07.07	Дорнод	Дашбалбар	Эрдэнэ толгой-1	Эрэн скай ХХК
6	ХУ-017562	2009.07.07	Дорнод	Дашбалбар	Эрдэнэ толгой-1	Эрэн скай ХХК
7	ХУ-018838	2015.07.07	Увс	Тариалан	Тариалан-2	Талын Монгол групп ХХК
8	ХУ-018836	2015.07.07	Увс	Тариалан	Тариалан-1	Талын Монгол групп ХХК
9	ХУ-018824	2015.07.07	Увс	Зүүнхангай	Хангай	Талын Монгол групп ХХК
10	ХУ-018728	2015.07.10	Говь-Алтай	Халиун, Цээл	Хөтөл	Талын Монгол групп ХХК
11	ХУ-018561	2015.06.15	Ховд	Манхан	Гео	Голденгео физик ХХК
12	ХУ-018673	2006.07.10	Ховд	Цэцэг	Алтаншан	Нөхөн загас ХХК
13	ХУ-018786	2006.07.10	Өмнөговь	Баяндалай	Бортолгой	Нэгүүндринлинг ХХК
14	ХУ-018904	2006.07.10	Баян-Өлгий	Ногооннуур	Дулаан	Эс Өү Би Би Ти майнинг ХХК
15	ХУ-015006	2009.07.20	Хөвсгөл	Бүрэнтогтох	Хавчиг	Эй Эс Ти Эс ХХК
16	ХУ-018139	2015.07.20	Баянхонгор	Баянговь, Баянцагаан, Шинэжинст	Нүд худаг	Чингис энержи групп ХХК
17	ХУ-018907	2015.07.20	Увс	Малчин, хяргас	Малчин	Талын Монгол групп ХХК
18	ХУ-018929	2015.07.20	Увс	Хяргас	Хяргас	Талын Монгол групп ХХК
19	ХУ-013914	2008.07.21	Дорноговь, Сүхбаатар	Дэлгэрэх, Баяндэлгэр, Түвшинширээ	Хүрэн-Уул	Талын-Элч ХХК
20	ХУ-016939	2008.07.23	Сүхбаатар	Баяндэлгэр	Хүрэн-Уул	Талын-Элч ХХК
21	ХУ-012576	2007.07.25	Сэлэнгэ	Түшиг	Хусмод	Хус мод ХХК

АМТГ-ЫН КАДАСТРЫН ХЭЛТЭС

ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронг

ДЭЭРЭМЧИД БУУ, ХУТГААР ЗЭВСЭГЛЭДЭГ БОЛЖ ДЭЭ

Сүүлийн үед дээрмийн гэмт хэрэг ихэсч, тэр ч бүү хэл өсвөр насны хүүхэд бусадтай бүлэглэн дээрмийн гэмт хэрэг үйлдсэн хэрэг гарсан билээ. Тодруулбал, Баянгол дүүргийн VI хорооны нутагт оршин суух 16 настай эрэгтэй Б-гийн "I Phone-5" гар утсыг тус дүүргийн V хороонд оршин суух 14 настай эрэгтэй Б гэгч бусадтай бүлэглэн зодож, дээрэмдсэн байх юм. Дээрмийн гэмт хэргийг ихэвчлэн бүлэглэн үйлдэж буй бөгөөд энэ сарын 08-нд автомат тоглоомын газарт зэвсэглэсэн этгээдүүд халдаж, дээрмийн гэмт хэрэг үйлдсэн нь олныг очирдуулсан. Тиймээс энэ удаагийн "Онцлох хуудас" булангаа дээрх хэргийн эргэн тойронд бэлтгэлээ.

ДӨРВӨН СЭЖИГТНИЙГ БАРИВЧИЛЖ, ХОЁРЫГ НЬ ХАЙЖ БАЙНА

2016.10.14: Галт зэвсэг, хүйтэн мээсээр сүрдүүлж, арав гаруй хүний биед халдсан бүлэг этгээдийг цагдаагийн байгууллага эрэн сурвалжилсаар байна. Одоогийн байдлаар гэмт хэрэг үйлдсэн зургаан сэжигтний дөрвийг нь баривчлан саатуулсан ч үлдсэн хоёрыг нь эрэн сурвалжилсаар байгаа аж. Баривчлан саатуулагдаад байгаа хоёр этгээдийн нэг болох Б нь өмнө нь хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт шалгагдаж байсан бөгөөд уг хэрэг нь одоо шүүхийн шатанд байгаа аж. Өөрөөр хэлбэл, Б нь батлан даалтад үйлдэж, ял шийтгэл эдлээд, өнгөрсөн долоодугаар сард Өршөөлийн хуулиар суллагдсан нэгэн ажээ. Тэднийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 147.3 дугаар зүйл анги буюу "Энэ хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, урьд нь уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол, бусдын бие махбодид хүнд гэмтэл учирсан бол эд хөрөнгийг хурааж арваас дээш хорин жил хүртэл хутагаагаар хорих ял шийтгэнэ" гэх зүйл ангиар буруутган саатуулаад байгаа юм. Хэргийн газраас зугтсан дөрвөн этгээд болон дээрэмдүүлсэн гэх мөнгө, бусад эд зүйлсийг мөрдөх албаныхан эрэн сурвалжилж байгаа аж. Түүнчлэн цагдаагийн байгууллага гэмт этгээд дээрэм хийхдээ ашигласан галт зэвсгийг хаанаас олж авсан болон дээрэмдүүлсэн 10 залуу олноороо шөнийн цагаар юу хийж байсан, дээрэмдүүлсэн гэх их хэмжээний мөнгө нь хууль бус байсан уу зэргийг нарийвчлан шалгаж эхэлжээ.

БУУТАЙ ЭТГЭЭДҮҮД ИХ ХЭМЖЭЭНИЙ МӨНГӨ ДЭЭРЭМДЭВ

2016.10.08: Энэ сарын 8-ны өдөр гар буу, хутгаар зэвсэглэсэн этгээдүүд автомат тоглоомын газарт дайран орж дээрэм хийж, танхайрсан хэрэг гарчээ. Сэжигтнүүд "АК-М" буу тулгаж, их хэмжээний мөнгө дээрэмдсэнээс гадна тэнд байсан хоёр иргэнийг хутгалж гэмтээсэн байна. Гэмт этгээдэд хутгалуулж, гэмтсэн Ч, Э нар ГССҮТ-д хүргэгдэн эмчлүүлж байгаа аж. Эл хэргийг шоронгоос суллагдсан "Шош" хочит этгээд үйлдсэн байж болзошгүй юм байна. Уг хэргийг Эрүүгийн цагдаагийн газар шалгаж эхэлжээ. Хэргийн мөрөөр Эрүүгийн цагдаагийн газар болон Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн албан хаагчид шуурхай ажиллаж, гэмт хэргийг үйлдсэн гэх А, Б нарыг баривчлалсан бөгөөд хамтран гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг илрүүлэхээр ажиллаж байгаа гэдгийг цагдаагийн байгууллагаас мэдээллээ. Түүнчлэн хэргийн улмаас алга болсон их хэмжээний мөнгө болон эд зүйлс, хэргийг үйлдэхдээ ашигласан галт зэвсгийг хайж байгаа юм байна. Гэмт хэргийг үйлдсэн этгээдүүдэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 147.3 дугаар заалтын дагуу эрүүгийн хэрэг үүсгэн, шалгаж байгаа аж.

ЁЛХАГВАСҮРЭН: ДЭЭРМИЙН ХЭРГИЙН УЛМААС АЛГА БОЛСОН ИХ ХЭМЖЭЭНИЙ МӨНГИЙГ ХАЙЖ БАЙГАА

2016.10.10: "Мөрийтэй тоглоомын газарт үл таних этгээдүүд дайран орж, 30 гаруй хүн хутгалж, гэмтээжээ" гэсэн мэдээлэл зарим мэдээллийн сайтуудаар тараад байгаа. Энэхүү мэдээллийн үнэн бодит байдлын талаар ЦЕГ-ын Хэвлэл мэдээллийн төвийн ажилтан Ё.Лхагвасүрэн "Энэ хэргийн талаар нэр бүхий мэдээллийн сайтуудад 34 хүн хутгалууллаа, мөрийтэй тоглоомын газар байсан гэхчилэн мэдээлж байгаа. Эдгээр мэдээллүүд ор үндэслэлгүй мэдээлэл гэдгийг онцолмоор байна. Хэргийн бодит нөхцөл байдал гэвэл 2016 оны аравдугаар сарын 10-ны өдрийн 00:00 цагийн үед Сүхбаатар дүүргийн 1-р хороонд байрлах орон сууцанд зодоон болоод байна гэсэн мэдээллийг иргэдээс цагдаагийн байгууллагад ирсний дагуу шалгахад тус орон сууцанд байсан 10 хүн рүү хэсэг бүлэг этгээд дайран орж, зэвсэг, зэвсгийн чанартай зүйлс ашиглан дээрмийн гэмт хэрэг үйлдсэн байсан. Хэргийн улмаас их хэмжээний мөнгө болон бусад эд зүйлс алга болсон. Уг гэмт хэргийг Эрүүгийн цагдаагийн газар болон дүүргийн Цагдаагийн хэлтсийнхэн түргэн шуурхай шалгаж, А, Б гэх этгээдүүдийг баривчлан, саатуулаад байна. Тэдэнд Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 147 дугаар зүйлийн 147.3-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Мөн А, Б гэх этгээдүүдтэй хамтран гэмт хэрэг үйлдсэн гэх нэр бүхий этгээдүүдийг дайчлан баривчлах, алга болсон их хэмжээний мөнгө болон бусад эд зүйлс, гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан галт зэвсэг зэргийг эрэн сурвалжилж олох ажиллагаанууд хийгдэж байна" хэмээсэн юм.



ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦАНД МӨРИЙТЭЙ ТОГЛОДОГ БАЙЖЭЭ

2016.10.11: Энэ сарын 08-нд гарсан "АК-М" буу тулгаж, их хэмжээний мөнгө дээрэмдсэн гэх хэрэг Сүхбаатар дүүргийн нэгдүгээр хорооны нутаг дэвсгэрт, БНСУ-ын ЕСЯ-ны хуучин байрны хажууд "Элчингийн хороолол"-д байрлах нийтийн орон сууцны ... тоотын таван өрөө байранд гарчээ. Хэрэг гарсан таван өрөө байрыг иргэн Х гэгч хоёр сая орчим төгрөгөөр түрээслэж авсан бөгөөд тус байранд тогтсон айл байдаггүй байжээ. Харин тус байрны ойр орчмоор хэдэн залуус эргэлдэх болсоор нэг сар орчим хугацаа өнгөрчээ. Түүнчлэн тус байранд үе үе бүлэг этгээдүүд цугларч, мөрийтэй тоглоом тоглодог байсан гэдгийг эх сурвалжууд хэлжээ. Хэрэг гарах үед цөөн тооны хүмүүс цугласан байсан гэх бөгөөд дээрх залуусаас гадна олон тооны хүмүүс хууль бус тоглоомд оролцдог аж. Цаашлаад хэд хэдэн эмэгтэй хүн мөрийтэй тоглоом зохион байгуулах ажлыг хийдэг, зарим үед барьцаанд тавьсан эд зүйлсийн эзэмшигчийн нэрийг шилжүүлэх үйлчилгээ хийдэг нотариатчид ирж ажилладаг байсан гэх мэдээлэл байгаа ажээ.

ХУТГАЛУУЛСАН ХОЁР ИРГЭНИЙ БИЕИЙН БАЙДАЛ ХҮНД БАЙНА

2016.10.11: Халдлагад өртөж дээрэмдүүлсэн гэх 10 хүн нь 25-31 насны залуус байсан бөгөөд дээрмийн үеэр мэсний шарх авсан хоёр иргэнийг яаралтай түргэн тусламжийн эмч нар Цэргийн госпитальд хүргэсэн байна. Мэсний шарх авсан хоёр иргэний биеийн байдал одоогоор маш хүнд байгаа бөгөөд нэг хүн ГССҮТ-ийн Гавал тархины тасагт хэвтэн эмчлүүлж байна. Харин бусад хүмүүс нь хөнгөн зэргийн гэмтэлтэй гарсан учир цагдаагийн байгууллагад тайлбар, мэдүүлэг өгч эхэлжээ.

Сэтгүүлчийн өнцөг

“АЛДАГДСАН ҮЕ”-ИЙНХЭН КИНО ШИГ Л АМЬДРААД БАЙГАА ЮМ БИШ ҮҮ

О.УЯНГА

Хулгай, дээрмийн хэрэг гарлаа гэх мэдээллийг уншихад үйлдэж байгаа хүмүүс нь ихэнхдээ л 1990-2000 оныхон байгаа. Бүр хэрэг болгоод хэдэн гэмт хэргийн мэдээ уншаад үзээрэй. Ерөнхийдөө энэ үеийнхэн гэмт хэрэгт холбогдох нь их байгаа. Яахав, 16-26 насныхан буюу ид үедээ яваа залуучууд болохоор алдах эндэх нь их байдаг л байх. Гэхдээ тэдний үйлдэж байгаа гэмт хэрэг нь ихэнхдээ хулгай, дээрэм байна. Нэг талаас нь харвал амар хялбар аргаар мөнгө олох гэсэн залуучууд хэт их олширч байгаатай холбож

тайлбарлаж болохоор. Нөгөө талаас энэ үеийнхний сэтгэхүй арай л өөр болчихож. Сүүлдээ бүр кино шиг амьдарч эхэллээ. Хар тамхи, гэмт хэрэгтэй байнга холбогддог. Бүр буу, хутгатай дайрч, их хэмжээний мөнгө дээрэмддэг боллоо. Саяхан гарсан хэрэг бол ерөөс барууны киноноос хардагтай адилхан юм болсон. Нэг хэсэг нь их хэмжээний мөнгөөр мөрийтэй тоглож л байдаг. Нөгөө хэсэг нь буугаар зэвсэглэж дээрэмдэж л байх. Тэгэхдээ бас болоогүй хүн хутгалж гэмтээсэн ч байх шиг. Амар тайван Монгол Улсад сүүлийн үед барууны кинонд үзүүлдэг шиг хэрэг их гардаг

...Дандаа л хөгшин настай хүний утас, түрийвч дээрэмдсэн. Эсвэл ганц нэгээрээ яваа залуучуудыг бүлэглэн зодсон, утсыг нь дээрэмдсэн хэрэг хийсэн нөхдүүд. Бүгдээрээ 20-25 насныхан...

болсон. Банк, ШТС, сүүлдээ бүр мөрийтэй тоглоомын газар дээрэмдэж байна. Нэлээд судалгаатай ажилласан нь мэдэгдээд байгаа юм. Тэгэхээр манай залуусын толгой нь тун сайн ажиллаж байгаагийн илрэл энэ. Гэвч зөв зүйлд эрээ ажиллаж чадахгүй байна. Өнөөдөр монголчууд мэдлэг боловсролоо дээшлүүлээд, чадвартай болоод, гайгүй цалин аваад, хуримтлал үүсгээд амьдрах нь хамгийн зөв зам гэдгийг ойлгохгүй байна. Яг ч нийтээрээ биш л дээ, нийм ухамсартай хүмүүс олон бий. Тэгэхдээ ихэнх нь улсаас зүгээр мөнгө аваад, эсвэл гэнэт баяжиж, 20-сайхан амьдрах хүсэлтэй болчихсон. Тиймдээ ч чын бүрийн

хэрэг төвөгт орооцолдож, хайран сайхан залуу насаа үрж байна. Саяхан ажлын шаардлагаар Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн гуравдугаар хэлтэс дээр нэг орой суулаа. Гэтэл 20 гаруй насны залуучууд л бөөн бөөнөөрөө ирж байна. Хоорондоо зодолдсон, архиан согтуурсан, дээрэм хийсэн гээд л. Тэр дундаа дээрэм хийсэн гэсэн залуучууд хэд хэд ирж байна билээ. Дандаа л хөгшин настай хүний утас, түрийвч дээрэмдсэн. Эсвэл ганц нэгээрээ яваа залуучуудыг бүлэглэн зодсон, утсыг нь дээрэмдсэн хэрэг хийсэн нөхдүүд. Бүгдээрээ 20-25 насныхан. Зарим нь бүр өмнө нь хэрэг хийгээд, Өршөөлийн

хуулиар суллагдсан ч байх шиг. Бид өнөөдөр Чингис хааны удам, хөх тэнгэрээс заяат монголчууд гэж хий хоосон цээжээ дэлдэж суухын оронд залуусаа арай өөрөөр хүмүүжүүлэх цаг болж. Оюун сэтгэхүйд өөр зүйл суулгаж, боловсролтой, мэдлэгтэй, хамгийн гол нь зөв хүн болгох хэрэгтэй байна. Тэгэхгүй бол залуучууд бэлэнчлэх сэтгэлгээтэй болоод хүмүүжээд байвал амар хялбараар мөнгө олохын тулд хүн хүртэл алж байна шүү дээ. Юун биеэ үнэлэх, дээрэмхийх, энүүхэнд болчихоод байна. Өнөөдөр буутай дээрэм хийж байгаа юм чинь маргааш буудалцаж "тоглох" ч юм бил үү, хэн мэдлээ.

ДЭЛХИЙ

Тайландын хаан тэнгэрт хальж, АНТонио Гутереш НУБ-ЫН ТЭРГҮҮН БОЛОВ

Б.ДАВААХҮҮ

Өнгөрсөн долоо хоногт дэлхий дахинаа болсон онцгой үйл явдлыг тойллон хүргэж байна.

Тайландын эзэн хаан таалал төгсөв

Дэлхийн хамгийн дург хугацаанд хаан ширээнд заларсан язгууртанд өргөмжлөгдөж байсан Тайландын эв нэгдлийн бэлгэдэл болсон эзэн хаан Пумипон Адульдет 88 насандаа өвчний учир тэнгэрт халилаа. Тэрээр сүүлийн нэг жил орчим хугацаанд эмнэлэгт хэвтсэн бөгөөд өнгөрөгч зургадугаар сард зүрхний мөс засалд орсон юм. Гэсэн ч биеийн байдал нь дээрдэлгүй улам муудсаар энэ сарын 13-ны өдөр таалал төгсчээ. Эзэн хаан таалал төгссөн мэдээлэл гарсны дараа ард иргэд нь түүний зургийг барин залбирч, уй гашуу болов. Эзэн хаан Пумипон Адульдет бол ядууралтай тэмцэх, хөдөө орон нутгийг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан хүн билээ.

Мөн тэрээр улс төрийн хямрал дэгдсэн хүнд үед улс орноо нэгтгэхэд чухал үүрэг гүйцэтгэж байсан юм. Тайландын нийслэл Бангкок хотод эзэн хааны шарилыг ачсан машины цуваа эмнэлгээс хааны ордныг чиглэн хөдлөх үед гудамж талбайд хэдэн зуун гашуудлын хувцастай хүмүүс цугларч, "Ард түмний хаан" хэмээн орь дуу тавин үйлж

байжээ. Тэд эзэн хаанаа эцсийн замд нь ийнхүү үдэж, цэргийн алба хаагчид нь ёслол хүндэтгэл үзүүлж байсан аж. Улмаар энэ сарын 30-ны өдрийг хүртэл улс орон даяар гашуудал зарлав. Энэ хүрээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг хоригложээ.

Португалийн Ерөнхий сайд асан НУБ-ыг тэргүүлнэ

Өнгөрсөн долоо хоногт өрнөсөн онцлох үйл явдлын нэг нь НУБ-ын дараагийн тэргүүн тодорсон үйл явдал байв. Нью-Йорк хотод хурал чуулганы төлөөлөгчид энэ сарын 13-ны өдрийн хуралдааны үеэр Бан Ги Мүний залгамжлагчийг тодруулахаар санал хурааж, улмаар дараагийн Ерөнхий нарийн бичгийн даргаар Португалийн Ерөнхий сайдаар ажиллаж байсан Антонио Гутереш сонгогдов. Тэрбээр үүрэгт ажилдаа 2017 оны нэгдүгээр сарын 1-нээс орох бөгөөд бүрэн эрхийн хугацаа нь таван жил юм. Антонио Гутереш 2015 оныг хүртэл НУБ-ын Дүрвэгчдийн асуудал эрхэлсэн дээд комиссараар ажиллаж байжээ.

Бан Ги Мүнийг залгамжлах дараагийн удирдагч нь эмэгтэй хүн, түүнчлэн зүүн Европоос гаралтай байх талаар олон таамаг гарч байв. Гэвч Антонио Гутереш 13 нэр дэвшигчтэй өрсөлдөн

сонгогдсон юм. Хамгийн гол нь Аюулгүйн зөвлөлийн гишүүн орнууд Гутерешийг санал нэгтгэж дэмжсэн нь ийнхүү түүний өмнө НУБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын суудалд томилогдох замыг зассан билээ. Ямартай ч, түүнийг 10 жил НУБ-ыг тэргүүлсэн Бан Ги Мүнээс ч илүү том үүрэг хариуцлага хүлээж байгааг эх сурвалжууд онцолж байна.

Трам Хилларид хар тамхины шинжилгээ хийлгэхийг хүсэв

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль ирэх сарын 8-нд болно. Сонгуулийн хугацаа тулсан энэ үед нэр дэвшигчдийн өрсөлдөөн улам ширүүсч байна. Энэ сонгуульд Бүгд Найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп, Ардчилсан намаас Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон нар өрсөлдөж буй билээ. Тэдний хамгийн сүүлчийн буюу гурав дахь удаагийн халз мэтгэлцэн орон нутгийн цагаар лхагва гарагт болох юм.

Тэгвэл Доналд Трамп хамгийн сүүлчийн халз мэтгэлцээнээс өмнө Хиллари Клинтонг хар тамхины шилжилгээнд хамруулах ёстой гэж мэдэгдсэн нь дуулиан тариллаа. Тэрбээр Нью Хэмпшир мужийн Портсмут хотод болсон уулзалтын үеэр "Клинтонд юу тохиолдсоныг нь сайн мэдэхгүй юм. Өнгөрсөн удаагийн халз мэтгэлцээний

...Доналд Трамп хамгийн сүүлчийн халз мэтгэлцээнээс өмнө Хиллари Клинтонг хар тамхины шилжилгээнд хамруулах ёстой гэж мэдэгдсэн нь дуулиан тарьсан юм. Тэрбээр Нью Хэмпшир мужийн Портсмут хотод болсон уулзалтын үеэр "Клинтонд юу тохиолдсоныг нь сайн мэдэхгүй юм...

эхэнд тэр их л зориг орсон мэт харагдаж байсан. Гэхдээ эцэстээ хачин болчихсон. Тамирчдад сэргээшийн шинжилгээ хийдэг шүү дээ. Яг түүн шиг АНУ-ын сонгуульд нэр дэвшигчдэд ч гэсэн халз мэтгэлцээнд орохын



өмнө хар тамхины шинжилгээ хийх шаардлагатай гэж бодож байна" гэж ярьжээ.

ОХУ-ын "Адмирал Кузнецов" газар дундын тэнгисийг зорилгоо

ОХУ-ын онгоц тээвэрлэгч "Адмирал Кузнецов" Сирийн босогчдын эсрэг агаараас дэмжлэг үзүүлж буй тус улсын тэнгисийн цэргийн хүчнийхний байрлаж буй газар дундын тэнгис дэх баазыг чиглэн хөдөлжээ. Энэ талаар тус улсын Батлан хамгаалах яамнаас мэдээлсэн байна. Энэ явдлаас хэдэн долоо хоногийн өмнө ОХУ-ын Батлан хамгаалахын сайд Сергей Шойгу онгоц тээгчийг газар дундын тэнгис рүү илгээж, ОХУ-ын тэнгисийн цэргийнхний хүчийг нэмэгдүүлнэ гэдгээ мэдэгдээд байсан юм.

Гэсэн ч, хэзээ хөдлөх нь тодорхойгүй байсан билээ.

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН 2016 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН ХӨДӨЛГӨӨНИЙ МЭДЭЭ

АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг / хот	Сум / дүүрэг	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	Эзэмшигч	Эзэмшигчийн регистр #	Шийдвэрийн огноо	Шийдвэр #	Олгосон огноо
1	XV-001017	Дундговь	Өлзийт	Хайрхан	4 628,42	Гурвансайхан	2074737	2016.07.22	509	2016.09.20
2	XV-001018	Дундговь	Гурвансайхан	Гурвансайхан	2 810,44	Гурвансайхан	2074737	2016.07.22	510	2016.09.20
3	XV-001021	Дундговь	Баянжаргалан	Чойр	6 282,01	Гурвансайхан	2074737	2016.07.22	511	2016.09.20
			Өндөршил		4 104,23					
4	XV-001068	Сүхбаатар	Түвшинширээ	Өлзийт	7 451,20	Гурвансайхан	2074737	2016.07.22	512	2016.09.20
			Уулбаян		3 214,02					
5	XV-009965	Дорнод	Матад	Цагаан чулуут	2 521,63	Буман-Олз	5108799	2016.07.06	494	2016.09.22
6	XV-014710	Улаанбаатар	Налайх	Харганат-2	26,46	Хастуа	5058996	2016.09.21	12	2016.09.27
7	XV-019025	Завхан	Ургамал	Од	1 639,24	Форс голд майнинг	6088759	2016.09.13	01	2016.09.20
8	XV-019151	Дорноговь	Сайхандулаан	Урд залаа	203,86	Мегатек мануфактуринг монголиа	5962862	2016.09.22	17	2016.09.22

ШИЛЖҮҮЛСЭН

д/д	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг	Сум	Талбайн нэр	Талбайн хэмжээ	Шилжүүлсэн хэлбэр	Эзэмшигч	"Эзэмшигчийн Регистр"	"Шилжүүлэн авагчийн нэр"	"Шилжүүлэн авагчийн регистрийн дугаар"	"Шийдвэрийн огноо"	"Шийдвэрийн дугаар"
1	MV-014548	Сэлэнгэ	Хүдэр	Будүүний гол	550,53	Бүхэлд нь	Алтайконтракшн	2761165	Бэйсикметал майнинг	5429196	2016.09.13	01
2	MV-016901	Сэлэнгэ	Ерөө	Уулзвар	41,91	Бүхэлд нь	Сэлэнгэмайнинг	2652811	Жинжий майнинг	6008194	2016.09.20	08
3	MV-017310	Төв	Алтанбулаг	Дунд бөхөг	25,21	Бүхэлд нь	Шижирхайрга	5167256	Хонгор холдинг	5663989	2016.09.20	09
4	MV-017399	Хэнтий	Жаргалтхаан	Тугалтай-2	294,37	Бүхэлд нь	Тефис майнинг	2807459	Космо каол	5673569	2016.09.21	14
			Мөрөн		11 395,81	Бүхэлд нь						
5	MV-017401	Хэнтий	Мөрөн	Тугалгатай	1 762,30	Бүхэлд нь	Тефис майнинг	2807459	Космо каол	5673569	2016.09.21	15
6	MV-019331	Дорноговь	Даланжаргалан	Зүүн далан	5 488,42	Бүхэлд нь	Тефис майнинг	2807459	Космо каол	5673569	2016.09.21	16
7	XV-017947	Ховд	Алтай	Дов	1 030,28	Бүхэлд нь	Ковертдайлинг майнинг	5497272	Бүрдэнговь Групп	5036909	2016.09.28	18
			Мөст		389,87							
			Үенч		1 255,83							
8	XV-018150	Ховд	Үенч	Хужирт	6 998,91	Бүхэлд нь	Энх-Өсөх	2882086	Алт-Импэкс	2681692	2016.09.20	10
9	XV-019491	Дундговь	Өндөршил	Говь-Эрдэнэ	17 952,23	Бүхэлд нь	Хэй лун жан хуа нян минерал	5685257	Цайна инвестмент монголиа	5767865	2016.09.28	20
10	XV-019510	Өмнөговь	Цогтцайц	1	1 314,97	Бүхэлд нь	Шижиа инвестмент	5775213	Цайна инвестмент монголиа	5767865	2016.09.28	25
11	XV-019564	Булган	Бүрэгхангай	Шар ус	300,82	Бүхэлд нь	Очир гео	5504635	Өсөх түмэн баясах	5654769	2016.09.19	04
12	XV-019770	Өмнөговь	Баяндалай	Сайхан хад	8 188,07	Бүхэлд нь	Шижиа инвестмент	5775213	Цайна инвестмент монголиа	5767865	2016.09.28	22
13	XV-019809	Булган	Бүрэгхангай	Тээл	853,91	Бүхэлд нь	Хүслэмж	2872722	Платинумланд	5076285	2016.09.28	19
14	XV-019870	Өмнөговь	Цогт-Овоо	Сайхан хад	7 428,25	Бүхэлд нь	Шижиа инвестмент	5775213	Цайна инвестмент монголиа	5767865	2016.09.28	23
15	XV-020105	Дорнод	Гурванзагал	Говь-Эрдэнэ	14 920,73	Бүхэлд нь	Шижиа инвестмент	5775213	Цайна инвестмент монголиа	5767865	2016.09.28	24
16	XV-020161	Дорнод	Чулуунхороот	Чулуут	15 979,34	Бүхэлд нь	Хэй лун жан хуа нян минерал	5685257	Цайна инвестмент монголиа	5767865	2016.09.28	21
17	XV-020331	Дундговь	Өндөршил	Чулуут	635,38	Бүхэлд нь	Нэгүүндриллинг	5669812	Алтан хүрд проспектинг	5941601	2016.09.20	07

БАРЬЦААЛСАН

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг / хот	Сум / дүүрэг	Талбайн нэр	Талбайн хэмжээ (га)	Эзэмшигч	Эзэмшигчийн регистр #	Барьцаалагч	Барьцаалагч #	Шийдвэрийн огноо	Шийдвэр #
1	MV-012415	Дархан-Уул	Хонгор	Зоолуу хар	190,30	Очир-Ундраа	2659603	Голомтбанк	2075377	2016.09.28	26

ТАЛБАЙГ БУЦААН ӨГСӨН

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг / хот	Сум / дүүрэг	Талбайн нэр	Буцаасан талбайн хэмжээ (га)	Буцаасан хэлбэр	Эзэмшигч	Эзэмшигчийн регистр #	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар
1	MV-015651	Баянхонгор	Жаргалант	Мандалын голын адаг	5,82	тодорхой хэсгийг	Оргыл моунт	5912245	2016.09.20	5
2	XV-012703	Дорнод	Чойбалсан	Бор толгой	4 418,42	тодорхой хэсгийг	Уэлт-Эксплорэйшн	5514983	2016.09.20	5
3	XV-012704	Дорнод	Дашбалбар	Гандан шил	17 827,70	тодорхой хэсгийг	Трежур-Эксплорэйшн	5515017	2016.09.20	6
4	XV-012705	Дорнод	Чойбалсан	Цооногтын шил	17 492,17	тодорхой хэсгийг	Империал метал групп	5625254	2016.09.20	5

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР КАДАСТРЫН ХЭЛТЭС

ШУУРХАЙ МЭДЭЭ

ШИНЭ ТӨРСӨН ХҮҮХДҮҮД 502, 567 БОСГО ОНООНЫ ДАГУУ ХҮҮХДИЙН МӨНГӨӨ АВНА

Н.БАТЗАЯА

Нийгмийн халалжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Мандхайгаас хүүхдийн мөнгөний талаар зарим зүйлийг тодрууллаа.

-Хүүхдийн мөнгийг хоёр хувааж олгоно гэсэн. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

-Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолоор "Хүний хөгжил сан"-гаас хүүхдийн мөнгийг олгох тухай баталсан. Харин улс орны эдийн засгийн нөхцөл байдалд уялдуулан энэ жил УИХ-аас 38 дугаар тогтоолыг батлан гаргасан. Уг тогтоолын дагуу 0-18 насны хүүхдүүдэд амьжиргааны төвшнөөс хамааран хоёр өөр зохицуулалтаар мөнгийг нь олгохоор болсон. Өөрөөр хэлбэл, өрхийн мэдээллийн нэгдсэн санд байрлаж байгаа амьжиргааны төвшний 502, 567 гэсэн босго онооноос доогуур оноотой 660 мянган хүүхдэд мөнгийг нь хуучин жишгийн дагуу бэлнээр олгоно. Харин үлдсэн 400 мянга орчим хүүхдийн мөнгийг 2019 онд олгохоор болсон. Хэрвээ босго оноо нь 502, 566-оос дээш бол 2019 онд хүүхдийн мөнгөө авна гэсэн үг.

-Амьжиргааны төвшний 502, 567 босго онооны талаар тайлбарлахгүй юу. Хөргөгч, угаалгын машинтай байх эсэх босго оноонд нөлөөлсөн үү?

-Өрхийн амьжиргааны төвшин тогтоох судалгаа Монгол Улсын хэмжээн дэх зорилгод бүлгийн тоог гаргах зорилготой. Уг судалгаанд үндэслэн зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээ, тусламж үзүүлдэг. Ер нь Өрхийн нэгдсэн сан байгуулах Засгийн газрын зорилтот үйл ажиллагаа гэж ойлгож болно. Энэхүү ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 2008 оны Засгийн газрын үеэс хэрэгжүүлж эхэлсэн. Одоогийн байдлаар бид гурав дахь удаагийн мэдээлэл цуглуулалтаар өрхийн

нэгдсэн сангийн мэдээллийг шинэчлэхээр ажиллаж байна. Иргэдийн дунд хөргөгчтэй, телевизтэй учраас босго оноонд тэнцсэнгүй гэсэн ойлголт бий. Ер нь өрхийн амьжиргааны төвшинг тодорхойлох судалгааны мэдээллийг цуглуулж, өрхийн амьжиргааг тодорхойлохдоо Үндэсний статистикийн хороо, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хамтран баталсан аргачлалаар, тодорхой батлагдсан асуумжийн дагуу судалгааг авч өрхийн амьжиргааны түвшинг үнэлдэг. Эдгээр асуумжуудыг тухайн өрхийн амьжиргаанд хамгийн их нөлөө үзүүлж байгаа хэрэглэний үзүүлэлтүүдээс сонгон авч боловсруулдаг юм. Нийт 59 асуулт байдаг. Асуумж дотор байгаа асуултууд нь амьдарч байгаа байршлаас хамаараад гурван өөр загвартай. Тухайлбал, Улаанбаатар хотод амьдардаг иргэн болон хөдөө амьдардаг хүний хэрэглээ харилцан адилгүй. Тэгэхээр байршлаас шалтгаалаад амьжиргааны төвшинг тодорхойлж, улмаар хүүхдийн мөнгөнөөс хасагдах эсэх нь шийдэгдэж байгаа гэж ойлгож болно. Түүнээс биш зурагттай, хөргөгчтэй эсэх хамааралгүй.

-Хүүхдийн мөнгө авах босго оноонд тэнцсэн эсэхээ хэрхэн мэдэх вэ?

-Иргэд босго оноотой холбоотой санал, хүсэлтийг харьяа газрынхаа хөдөлмөр, нийгмийн хамгааллын ажилтанд гаргаж болно. Хэрвээ хүүхдийн мөнгө авах эсэхээ мэдэхгүй байвал нийгмийн ажилтандаа хандаад мэдэх боломжтой.

-Шинэ төрсөн хүүхдүүд мөнгөө 2019 онд авах уу?

-Шинээр төрсөн хүүхдүүд ч ялгаагүй 502, 567 босго оноогоор мөнгөө авна.

-Хүүхдийн мөнгө нь дансанд нь ороогүй байгаа эцэг, эхчүүд "Манай хүүхэд хүүхдийн мөнгөнөөс хасагдчихлаа" гэх ойлголттой байна. Зарим хүүхдэд яагаад 2019 онд хүүхдийн мөнгийг нь олгохоор зохицуулсан юм бэ?

-7,8,9 дүгээр сарын хүүхдийн мөнгө хэвийн олгогдож байна. Иргэд ийн дунд "Манай хүүхэд хүүхдийн мөнгөнөөс хасагдчихлаа", "Хүүхэд маань авахгүй үлдчих вий" гэж санаа зовох шаардлагагүй. "Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох" журмын дагуу бүх хүүхэд мөнгөө авна. Харин мөнгөө гар дээрээ авах цаг хугацааны хувьд зохицуулалт хийгдсэн гэж ойлгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, дансанд тань хадгаламж хэлбэрээр байрших юм. Ингээд 2019 оноос бэлнээр авах боломж бүрдэнэ.



Цэрэг татлагын хугацааг хойшлуулжээ

Цэрэг татлага орон даяар аравдугаар сарын 15-нд эхэлдэг билээ. Тэгвэл энэ жилийн хоёрдугаар ээлжийн цэрэг татлага орон нутгийн сонгуультай давхцаж байгаа учраас цэрэг халах, татах хугацааг аравдугаар сарын 20-нд зохин байгуулахаар болжээ. Тодруулбал, цэргийн албанд залуучуудыг татах, нэгдүгээр ээлжийн хугацаат албаны цэргүүдийг халах, гэрээт цэргийн албанд элсүүлэх ажил нийслэлд энэ сарын 21-23, хөдөө орон нутагт 20-28-ны өдрүүдэд болох юм байна. Цэрэг татлагын зарлан дуудах хуудас авсан залуус цэргийн үүрэгтний үнэмлэх, цахим үнэмлэх, эрүүл мэндийн даатгалын дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр, хэрэв оюутан бол оюутны холбогдох материалаа бүрдүүлж, дурдсан цэрэг татлагын байранд очихыг санууллаа.

Энэ лхагва гарагт бүх нийтээр амарна

Нийслэлийн Засаг дарга С.Батболд "Сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай" А/722 дугаар захирамж гаргалаа. Тус захирамжаар Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдөр буюу 2016 оны аравдугаар сарын 19-нд нийтийг хамарсан арга хэмжээг бүртгэж, зөвшөөрөл олгохгүй байхыг нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газарт, соёл урлаг, үзвэр, спортын арга хэмжээ зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохин байгуулахгүй байхыг нийслэлийн Соёл, урлагийн газарт тус тус даалгасан байна. Мөн сонгуулийн санал авах болон техникийн тооллого хийх өдөр буюу 2016 оны аравдугаар сарын 19, 20-нд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр зогсоолоо. Түүнчлэн энэ өдрүүдэд гарч болзошгүй гэмт хэргэ зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний ачааллыг бууруулах бийрүүлэх нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хүнс, барилгын материал, мод, модон материал, түүхий эд, техникийн захууд болон худалдааны төвүүдийн тухайн долоо хоногийн амралтын өдрийг сонгуулийн санал авах өдөр буюу 2016 оны 10 дугаар сарын 19-ний өдөр шилжүүлэхийг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгожээ.

PHOTO NEWS



Нийслэл хот үүсэн байгуулагдсаны 377 жилийн ойг угтан нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Аялал жуулчлалын газар хамтран Богд хан уулын "Зайсан-Баруун шифээт" чиглэлийн 3.6 км явган аяллын замд иж бүрэн тохижилт хийж өнгөрсөн бялба гарагт нээлтээ хийлээ. Тохижилтын хүрээнд явган аялагчдад зориулсан сандал, шифээ, сүүдэрч, хашлага, гүүр, мэдээллийн салбар болон Богд хан ууланд амьдардаг ан амьтдын танилцуулга, тайлбарыг байршуулсан байна.



Нийслэлийн Засаг дарга С.Батболд

Автобусны төлбөрийг утсаараа хийдэг болно

Автобусны "U Money" картын шинэчлэлийг ирэх сараас хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Энэ тэргүүнд заавал картаа уншуулж автобусаар зорчихоос өөр хэлбэрийг гаргасан байна. Тухайлбал, иргэд гар утасны симэндээ автобусны картын чипийг суулгах юм. Ингээд автобусанд гар утсаа уншуулаад үйлчлүүлэх боломж нээгдэх аж. Эхний ээлжид "Юнител" компанитай гэрээ байгуулаад чиптэй сим картаа оруулж иржээ. Удахгүй худалдаанд гарах юм байна. Харин бусад операторуудтай уулзалт хийж, мэдээлэл солилцох шатандаа явж байгаа талаар "Улаанбаатар смарт карт" компаниас мэдээллээ. Мөн гар утсанд холбогдсоноор онлайнгаар цэнэглэх боломж нээгдэх юм. Үүнээс гадна банкны картуудад чипээ суурилуулах боломжийг бүрдүүлж байгаа гэв. Эхний ээлжид Худалдаа хөгжлийн банк, Голomt, Хаан банкны картанд чип суулгадаг байхаар тогтжээ. Учир нь иргэд түрийвчэндээ олон төрлийн карт авч явдаг бөгөөд энэ нь төвөгтэй байдаг байна. Тиймээс эдгээр картыг нэгтгэх үйлчилгээг хэрэгжүүлэхээр болсон аж.

Давтан зөрчил гаргасан микро автобусыг 576 мянгаар торгоно гэв

Нийслэлийн Тээврийн газраас насжилт дууссан микро хулгайгаар тээвэрлэлт хийх тохиолдол буурахгүй байгааг мэдээлж байна. Хулгайгаар тээвэрлэлт хийж байгаад баригдвал Автогэврийн тухайхуулийн 23.1.4-ийн дагуу 5-30 мянган төгрөгөөр торгоно.

Харин хоёр дахь удаа тээвэрлэлт хийж, баригдвал тухайн тээврийн хэрэгслийг журмын хашаанд хийх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 576 мянган төгрөгийн мөнгөн торгууль оногдуулах аж. Энэ

оны наймдугаар сарын 1-нээс 176 микро автобусыг нийтийн тээврийн үйлчилгээнээс бүрмөсөн чөлөөлжээ. Шаардлага хангасан 48 микро автобусыг үйлчилгээнд явуулахаар болсон юм байна.

Барилга дээрээс үсэрч, амиа хорлохыг завджээ

Сүүлийн үед иргэдийн дунд амиа хорлох тохиолдол ихэссэн билээ. Тэгвэл өнгөрсөн баасан гарагт Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны 11 дүгээр байрны таван давхраас хүн үсэрч

амиа хорлохыг завдсан хэрэг гарчээ. Тодруулбал, баасан гарагийн шөнө 01:12 цагт Шуурхай удирдлагын төвд хэргийн талаархи дуудлага ирсэн байна. Тус дуудлагын дагуу Нийслэлийн Онцгой

байдлын газрын Аврах ангийн зургаан албан хаагч, нэг автомашинтай ажиллаж иргэн А-г өндрөөс буулгасан ажээ. Аврах ажиллагааны дараа уг хэргийг цагдаагийн газарт шилжүүлсэн байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

ИХЭНХ НУТГААР ЦАС ОРЖ, ХҮЙТЭРНЭ

Энэ сарын 17-нд нутгийн хойд хэсгээр, 18-нд төв болон зүүн аймгуудын хойд, 19-нд баруун аймгуудын баруун хэсгээр, 20-нд баруун болон төвийн аймгуудын зарим нутгаар хур тунадас, цас орно. Салхи ихэнх хугацаанд зарим газраар секундэд 12-14 метр хүрч ширүүснэ. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтэйн уулархаг нутгаар шөнөдөө 10-15 градус хүйтэн, өдөртөө 3 градус дулаанаас 2 градус хүйтэн, говийн бүс нутгийн өмнөд хэсгээр шөнөдөө 1 градус хүйтнээс 4 градус дулаан, өдөртөө 14-19 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан байхыг Ус цаг уурын орчны хүрээлэнгээс анхаарууллаа.



БХИС-95 ЖИЛ

БХИС чиньтсийн хэрэмжит болохоо шахсан нь

Д.ГҮНЖИЛМАА

Ардын хувьсгалтай эн чацуу Батлан хамгаалахын их сургууль анх морин цэрэг, артилерийн богино хугацааны дамжаанаас Монгол улсын томоохон их сургууль болон хөгжсөн энэхүү түүхэн хугацаанд 70 гаруй мянган төрөл мэргэжлийн боловсон хүчнийг сурган бэлтгэсэн байдаг юм байна. Монголдоо төдийгүй дэлхийд данстай томоохон сургууль болон ийнхүү хөгжихөд энэ сургуулийг үүсгэн байгуулагдсан, удирдан чиглүүлж байсан, багшилж, судалгаа шинжилгээ хийж байсан үе үеийнхний хичээл зүтгэл, ажил үйлс нэн чухал үүрэг гүйцэтгэсэн нь гарцаагүй. Бид тэдний төлөөлөл болгон 2005-2010 онд тус сургуулийг удирдаж байсан доктор, профессор, БХИС-ийн Хүндэт доктор, генерал Нанзаддоржийн Жалбажавтай уулзаж ярилцлаа.

1992-1996 онд түмний итгэл хүлээн УИХ-ийн гишүүнээр ажиллан хууль батлагдаж байсан эрхэм маань өдгөө “Шихихутаг” хууль зүйн дээд сургуулийн удирдлагуудын нэг юм байна. Тийм болоод ч тэр үү, тэрбээр саяхан батлагдсан Цэргийн албаны эрх зүйн байдлын тухай багц хуулийн талаар ярьж, түүнд Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны нэгэн чухал субъект болох БХИС-ийн талаар ч авч үзэснэд олзуурхаж ярьж танилцсан юм.

“Юуны өмнө танд баярын мэнд хүргэе?”

“Баярлалаа, эрдмийн уурхай болсон сургуулийн маань 95 жилийн ой болж байна. Бид энэ хугацаанд зөвхөн нэрээ төдийгүй бодлого, үйл ажиллагааны чиглэлээ зургаан удаа өргөжүүлэн тэлж, боловсронгуй болгосон байдаг. Манай сургууль Монголдоо төдийгүй дэлхийд данстай томоохон сургууль болж ийнхүү хөгжсөн нь энэ сургуулийг үүсгэн байгуулагдсан, удирдаж байсан, багшилж байсан үе үеийнхний ажил хөдөлмөр, хичээл зүтгэлийн үр дүн юм шүү дээ. Би энд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор Мягмар генерал, Монгол Улсын гавьяат багш Г.Мягмаржав, одоогийн сургуулийн захирал Я.Чойжамц нарын хичээл зүтгэл нэн ихийг онцлон хэлэхийг хүсч байна. Мөн энэ сургуулийг дүүргэж, ажил амьдралынхаа гарааг эхэлсэн, азтай, амжилттай ажиллаж яваа нийт бие

...Ер нь цэргийн сургуулийн захирал байна гэдэг нэлээд сайн дипломатч, менежер, санхүүч, лидер байх ёстой юм шиг байна лээ шүү. Манай БХИС чинь үеийн үедээ салбартаа гадаад харилцааг өнгөлж ирсэн юм шүү дээ...

бүрэлдэхүүн, төгсөгчдийн маань ч хувь нэмэр бий.

“Та хэдэн онд энэ сургуулийг удирдаж байв аа?”

“2005-2010 оны хооронд миний бие энэхүү сургуулийг удирдан ажилласан. Тэр үед АНУ-д Монгол Улсыг төлөөлөн сууж байсан Элчин сайд, хурандаа Р.Болд доктор санаачлан манайг БХИС-ийн захирал болонгуут Америкийн бүхий л цэргийн их, дээд сургуулиудаар орж, танилцах боломж олгосон. Тэндээс ирээд манайхан энхийг дэмжих ажиллагаа, терроризмтай тэмцэх ажиллагааны сургалтын хөтөлбөрийг боловсруулж, сурах бичиг, гарын авлагыг бэлтгэж, тэр чиглэлээр боловсон хүчин, багш нарыг бэлтгэхэд анхаарлаа хандуулсан. Мөн сургуулийн орчин, суралцах боломж нөхцлийг сайжруулахыг чухалчилсан. Өнөөдрийн тухайд, шат шатны сургууль, хичээл сургалтын иж бүрдэл байр, сургалт дадлагын цэргийн анги, дотуур байр, номын сан, спорт цогцолбор, жинхэнэ эконо-ногоон орчин гээд оюутан сонсогчдод шаардлагатай бүхэн цогцолсон их дээд сургууль Батлан хамгаалахын их сургуулиас өөр байхгүй гэж боддог.

“Монголоороо гоёно гэдэг дээ. Та энэ дашрамд сургуулиараа нэг бахархаач?”

“БХИС-ийг төгсөгчид маань Монголын баглан хамгаалах, зөвсэгт хүчний ноён нуруу болж байна. Энхийг дэмжих ажиллагаанд оролцогчид, эрдэмтэн судлаачид, цэргийн дээд

цолтон генералуудын дийлэнх нь манай сургуулийн төгсөгчид байдаг. Манай төгсөгчид зөвхөн салбартаа төдийгүй улс орны бүхий л салбарт иргэн хүний төлөвшил, мэргэжлийн ур чадвараараа үлгэрлэн манлайлж чаддаг.

“Тэгвэл би энэ мөчид генерал хэмээх таны сайхан цолоор “гангармаар” санагдчихлаа?”

“Найм дахь погон буюу цэргийн дээд цол шүү дээ. Генерал цол бол асар их хүндэтгэл, мэдлэг чадвар, хариуцлага. Цэргийн албыг пирамид гэж үзвэл яахын аргагүй орой нь генерал юм. Батлан хамгаалах, аюулаас хамгаалах бүхий л чухал салбарт мэдлэг чадвар төгс хурандаа, удирдах түвшний хүмүүсийг нэгтгэн чиглүүлэх чадвартай байна гэдэг генералаас ямар чадвар шаардагдах нь ойлгомжтой. Генералууддаа манай улс хүндэтгэлтэй ханддаг. Хамгийн сүүлийн жишээ гэхэд сая батлагдсан багц хуулиндаа генералуудад цолны мөнгийг сар бүр олгож байхаар тусгасан байна.

“Ер нь энэ 95 жилийн хугацаанд хэдэн захирал ажилласан байдаг юм бэ?”

“Анхны захирал нь Зөвлөлтийн мэргэжилтэн П.М.Толпыгин гэдэг орос хүн байсан. Түүнээс хойш 44 захирал энэ сургуулийг удирдаж байсан. Тэдгээрээс Н.Содном захирал улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн гашуун түүхтэй. Эх оронд маань аюул нүүрлэсэн цагт өөрөө хэерийн сургуулиа удирдаж, жинхэнэ тулаанд орж байсан Цэргийн сургуулийн захирал хэлмэгдэж, хоригдож, тамлуулж, эцэст нь буудуулж нас барсан тухай баримтат кино миний удирдаж байх үед хийгдэж байлаа. Хэлмэгдүүлэлтийн үеийн хар бараанамьдралын үнэнийг өгүүлсэн тэр кино харамсалтай нь олонд тараагүй. Энэ дашрамд хэлэхэд, Монгол Улс Батлан хамгаалахын сайдаараа төрийн ноён нуруу болохуйц түшээдэе ямагт илгээдэг. Ж.Ёндон, Жадамбаа, Шаравдорж, М.Сономпил, Дорлингжав гээд намын харьяалал харгалзахгүй сайн хүмүүсийг томилдог байсан, тэд нь Батлан хамгаалах их сургуулийг харж үздэг байсан.

“Та сургууль удирдаж байх үеийнхээ онцлог сонин зүйлээс дурдаач?”

“Ер нь цэргийн сургуулийн захирал байна гэдэг нэлээд сайн дипломатч, менежер, санхүүч, лидер байх ёстой юм шиг байна лээ шүү. Манай БХИС чинь үеийн



үедээ салбартаа гадаад харилцааг өнгөлж ирсэн юм шүү дээ. Гадны 15 орны цэргийн их дээд сургуулиудтай шууд холбоотой. Батлан хамгаалахын их сургуулийн багш, эрдэмтэн судлаачид очиж судалгаа хийдэг, туршлага солилцдог, оюутан сонсогчид солилцоогоор очиж сурдаг. Тэр чиглэлээр ч миний үед багагүй зүйл хийгдсэн. Мөн тариа хураалтад явах, байшин барилга барих, мал аж ахуй хөгжүүлэх зэргээр сургуулийнхаа хэвийн үйл ажиллагааг хангаж, эдийн засгийн хүнд хэцүү он жилүүдийг давж гарсан юм. Үүнд сургууль хөгжүүлэх сан чухал үүрэгтэй байсан бөгөөд түүнийг одоо сэргээн батжуулахад буруудах зүйлгүй болов уу. Мөн нэг хөгтэй явдал дурдахад, М.Сономпил Батлан хамгаалахын сайд байхдаа манай сургуулийг Чингис хааны нэрэмжит болгоё гээд нэлээд хөөцөлдсөн ч хуучнаараа үлдэж чадсан юм. Харин би “Та цэргийн удирдах албан тушаалтан, тэгээд МАХН-аас нэр дэвшиж, УИХ-д сууж байсан хүн...тэгсэн атлаа сургуулийнхаа үүсгэн байгуулагч Д.Сүхбаатарын нэрийг Чингис гэж солих гэлээ, мөн сургуулийн захирал Содном хэлмэгдүүлэлтэд өртсөн талаар хар бараан кино хийлээ” хэмээн зэмлэлтэй үлдэж билээ.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 6
Шөнө -5

Нөгөөдөр
Өдөр 8
Шөнө -7

Өдрийн зурхай

Намрын адаг шар нохой сарын Таван шар мэнгэтэй Хар бич өдөр. Сумъяа гараг

Үс засуулбал: **Өвчин ирнэ**
Наран ургах, шингэх:
07:17 - 18:11



Өдрийн өнгө:
Тухайн өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус луулах, сүт дууаныг сэрээх, бүжиг наадал хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, голго тээжэхэд луу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, тогой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн ураги төрөө гаргавал зохистой. Тэрсүүд өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДУУЛГАХ СОНИН

Дуучин Аделийн цомог дахин дэлхийг шуугиуллаа


Хүчирхэг хоолой, хөдөлмөрч байдлаараа дэлхий нийтэд танигдсан дуучин Аделийн гаргасан цомог нь хэдэн сая хувь борлогддог. Тэгвэл түүний өнгөрсөн жил гаргасан “25” цомог Их Британийн дуу хөгжмийн түүхэнд хамгийн хурдан борлуулагдсан цомгоор тодорчээ. Уг цомог нь гарсан даруйдаа дэлхий даяар гурван сая хувь борлогдож байсан бол Их Британид эхний долоо хоногтоо 800 мянган хувь борлогдсон нь тус улсын түүхэнд байгаагүй дээд амжилтыг тогтоожээ. Ирэх он гэхэд тус цомгийн борлуулалт 20 саяд хүрэх төлөвтэй байгаа аж. Энэ хэрээр дуучин бүсгүйн ашиг орлого нэмэгдэх юм. Сонирхуулахад, дуучин бүсгүй хүүхэд гаргасныхаа дараа нэлээд жин нэмсэн ч өдөрт уудаг хоёр ширхэг ёотонтой цайнаасаа татгалзсанаар итгэмээргүй үр дүнд хүрч чаджээ.

Бидэнд тохиолдсон



Хүндхэн хөгтэй явдлууд
Тэмүгэ Тэмүжин Тэмүгэ Тэмүжин

Манай найз нэг хүүхэнтэй танилцаад хоорондоо мессежээр харилцдаг юм. Нөгөө хүүхэн нь бас англи хэлтэй. KISS YOU MY BABY гээд л ойр зуурын үг бичнэ. Найз маань арай гадарладагаар нь надаас асуудаг юм. Би чадахаараа л орчуулж өгнө дөө. Бас бологүй ээ манай найз намайг орчуулагч гээд бодчихсон. Хаха. Нэг өдөр найз маань “НЭЙС БОУЛ ТӨҮ гэж юу гэсэн үг вэ” гээд аймар галлиглаж ирээд л асууж байна. Би дотроо ямар үг байдаг юм бол гэж гайхаад л мессежийг нь харсан чинь NAS BOL TOO. Хаха би бүр тэнд саваад унасан.



Риогийн олимпис мөнгөн медаль хүртэж эх орныхоо нэрийг дэлхийн тавцанд гаргасан жүдоч Д.Сумъяагийн амьдралаас сэдэвлэн бүтээв.

Жирийн нэгэн албан хаагч залуу Итгэл нэг л өдөр гэнэтийн том амжилтад хүрч, “сайдын багийн хүн” болон түүний гарын үсэг олон хүний амьдралыг шийдэх болно. Өндөр албан тушаалд очсон ч найз Анхбаярынхаа хамгийн чухал ажлыг бүтээж чадалгүй сэтгэлээр унаж явахдаа эдгэшгүй өвчин туссан болохоо мэднэ. Хэрвээ чи маргааш үхэх байсан бол юу хийх вэ? Хамгийн сайн найзынхаа амьдралыг нь сүйрүүлж, хайртай бүсгүйдээ үнэнээ ойлгуулж чадалгүй, хол суугаа эцэг, эхээ үлдээгээд энэ хорвоог орхиж чадах уу?

100,000т ЭЗЭГНЭР КАРТ | 50,000т ЭЗЭГНЭР КАРТ | 30,000т ЭЗЭГНЭР КАРТ | ХЭВЭДЭГ ҮЭН ЭЗЭГНЭР КАРТ 8,000 | ХОСЫН КАРТ 15,000

ТЭНГИС ХЭВЭДЭГНЭР КАРТ

УДАХТЭЙ ТЭНГИСНИЙ ДЭЛЭГЭРЭЭ

ХАРААЛ | ОУЛАА | SHOOTER | TROLLS